

Хар үхэрт Д.Жамсранжав

Энэ хөшөө 5-р жарангийн хөхөгчин тахиа жил (1225 он) боссон бөгөөд 1818 онд Сибирийг судлагч Спасский гэгч Өргөн мөрөнд нийлдэг Үрлэнгүй голд цутгадаг Хархираа голын орчмоос Дорно зүгийн гэрэлт хөшөө олдсоныг мэдээлснээс хойш Ванчиков, Вильгельм Шмидт, Дорж, Банзаров, Вас.Радлов, Бонапарт, Ин.Илюкин, С.Мураяма, Г.Е.Румянцев, Хөдөөгийн Пэрлээ нарын арваад эрдэмтэн удаа дараа судалж ирсэн түүхтэй билээ.

Энэ бол бидэнд олдоод байгаа монголын түүх, хэл, соёлын маань эртний анхны дурсгалын нэг, одоо Эрмитажид бий. (Зөөгөөгүй байсан бол хугарахгүй байсан байж магадгүй.)

1962 онд доктор Х.Пэрлээ энэ тухайн судалгаануудыг нэгтгэн уг бичээсийн гол санааг гаргаад “Чингис хаан аян дайнаас нутагтаа ирж Буха Сужигай гэдэг газар Хорезмыг довтлон эзэлсэн дайны дүнг гаргасан хуралдай хийсэн”.⁽¹⁾ Бух сужигай гэдэг газар л олдвол энэ хөшөөний бичээсийг бүрэн уншлаа гэж болно гэж бичсэн нь бий.

Бух Сужигай “газрын нэр”⁽²⁾ гэтэл газрын нэрд ховор. Бух гэж байдаг. Бух Сужигайн гол утгыг хадгалж байгаа үг нь “Сужигай” юм. Бух гэдэг үг бол Монгол аман болон утга зохиолын хэлнээ өргөн хэрэглэгдэх атал “сужигай” ховор учраас энэ үгийг мөрдөж мөшгих хэрэгтэй болсон юм.

Би энэ хоёр үгээр хөөцөлдөж явсаар эрдэмтдийн судалгаа, Монгол утга зохиол, нутгийн аялгууны судлалд түшиглэн “Буха сужигай” орчин цагийн хэлээр “Бух сужиг”, газрын нэр биш “Их хүрээ” гэсэн үг байна. Ийм учир Чингисийн чулууны бичээсийг “Чингис хаан Сартаул иргэнийг даулж бууж хамаг монгол улсын ноёд их хүрээ хуригсан Есунхи онтудур-уун гурван зуут гучин таван алдас-дүр онтуудлаа” гэж уншиж байдаг юм.

Тодруулбал:

1. Эрдэмтдийн судалгаанд үзвэл энэ тухай бичсэн эрдэмтэд “сожигай” сочих, сожига(?)⁽³⁾, сочигай, сужигай”⁽⁴⁾ гэх мэт олон хэлбэрээр бичдэг нь энэ үг чухам юуг хэлдэг нь ярианы хэлнээ үгүй болсон уу, байна уу? Ямар ч судалгаа байгаагүйтэй холбоотой. Бичээсийг анх уншиж эхэлсэн орос орчуулгад “Чингис хан . . . последую временям .. Все монгольские народы . . .”⁽⁵⁾ гээд “Буха сужигайн” тухай дурдаагүй нь тэр үедээ илэрхий ойлгогдох үг, мэдэх юм байсан байж ч болно.

Түүнчлэн “когда Чингис хан соизволил овладеть сартальским народом и присоединить к древнему становищу всего монгольского народа находящиеся Вообщем по Онону побеждены 335-ю посланными”⁽⁶⁾ гэж Хиагтын монгол хэлний багш Ванчиков орчуулж байсныг үзвэл “Буха сужигай”-г “К древнему становищу” гээд бичээсэд байхгүй Онон мөрнийг оруулсан нь энэ үйл явдал хаана болсныг баталж “сужигай”-г мөн л “хүрээ хороотой” адил ойролцоо үг болохыг харуулж байна.

Үүнчлэн, 1833 онд академич Шмидтийн уншсанд “Буха сужигай”-г дээрх Ванчиковын адил “ноёдыг” гэснийг эртний гэж гаргасан учраас

мөн л суурин гэсэн санаагаар “Буга оргай”⁽⁷⁾ гэжээ. Шмидтийн уншснаас арваад жилийн дараа 1851 онд Эрдэмтэн Банзарын Дорж⁽⁸⁾ уг бие ээсийн нилээд үгийг түүх хэлний талаар нь өмнөх уншсанаас урагш нилээд ахиулсан бөгөөд Шмидтийн “Буга оргой хиругсан” гэж уншса ныг “Буга сочигай хуригсан” гэж залруулжээ.

Энэ “Буха сужигай” гэдэг нэрийг Буга сочих гэж ухаарч болохгүй, харин бух хүзүү, бух хоолой гэсэн үг байж магадгүй гэж бодов”⁽⁹⁾ гэж Х.Пэрлээ бичжээ.

2. Монгол хуучин утга зохиолд үзвэл XVII зууны үеийн “Асрагч, Нэртийн түүх” хэмээх зохиолд “бухан сэжүүр” гэж гардагчлан туульсын зохиолд, тухайлбал, “Жангар”⁽¹⁰⁾-т бух цэрэг (виц-а сereg) гэж бичсэн байх ба “Шарай голын гурван хаан”-ны цомнолд “Бух цэрэг хөдөлбөл бүх хэрэг бүтнэ” гэж гардаг. Үүнчлэн чулууны бичээсэд тухайлбал, уйгурын хар балгасны түрэг бичээсэд “Виц-а Kubegun minu ner-e”⁽¹¹⁾ гэж байна.

Орчуулгын зохиолд, жишээ нь “Хаан бука-су-джиху?» газар бууж их алтан орд барьж хуралтай хурж их хурим хийх зарлиг буулгав. Газрын хөрс нь үлтэрхий учир тоос дэгдсэнд Чингис хаан хүн бүр өөр өөрийн орд сууцны гадуур чулуу дэвсэх зарлиг буулгав...”⁽¹²⁾ гэсэнд ажиглавал бука-су-джихугийн ард асуултын тэмдэг тавьсан нь энэ тухайд баттай биш эргэлзээтэй байгаа нь илт. Дээрх орчуулга ерөнхий утгаараа бол “Хаан, их алтан орд барьж их хурим хуралдай хийх зарлиг буулгасанд их хүрээ хурж, газрын хөрс нь үлтэрхий, шороо тоостой байсан учир сууц ордныхоо хавиар чулуу дэвс гэж зарлиг буулгав” гэж ойлгогдож байна.

3. Нутгийн аялгууны судлал, ярианы хэлнээ ажвал “сужиг, сузга” гэдэг үг Монголчуудын дунд морины уяаны нэр байгаа нь өрнө, дорно, өмнөд нутгаар алаг цоог тохиолдож буй. Тухайлбал, Даригангад “сужиг”, Хөвсгөл аймагт “шузга”⁽¹³⁾, Завхан аймгийн Нөмрөг, Тэлмэн, Булнай, Бүрэнхаан сум, Говь-Алтай аймгийн зарим нутагт сузга”, Архангай аймгийн Цэнхэр суманд “шугшига”, Говийн зарим халхууд “цузга” гэхчлэн ойролцоо дуудлагатай бүлэг үгс байх ба үүнчлэн Хөвсгөл аймгийн Ринчинлхүмбэ, Улаан-уул, Баяннуур сумдад морины уяаг “цэрэг”, Цагааннуур суманд “хирэм” (хоёр модыг нь “сэргэ”), Хотгойдууд “цуцаг” (зарим нь “цацаг”), Буриадад “сэргэ”, сураг сонсвол Якутад ч “сэргэ” гэдэг гэнэ. Эрт дээр цагт “жиргэ” “жирээ”. гэдэг байжээ. Бүх монгол туургатны дотор бус гарын доор тохиолдсон энэ хэдэн жишээг үзэхэд “сужиг”-маш эртний гаралтай үг бөгөөд ярианы хэлнээ нутаг нутагт ойролцоо дуудлагатай уламжлагджээ. Эд бүхнийг ерөнхий утгаар нь үзвэл хоёр модны хооронд татсан хэц, хичнээн олон хэлбэрээр хэлж байвч хүрээ, хороо, хэрэм, хашаа гэсэн утга илтгэх сацуу, морьтон нэг доор бөөгнөрвөл “сужиг” татдаг нь одоо ч хэвээрээ л байна.

4. Толь бичгүүдэд ажиглавал: “сужиг” гэсэн үг толь бичигт үгүй, хамгийн ойролцоо үг нь “судаг”⁽¹⁴⁾ гэдэг үг бий. Монгол хэлний товч тайлбар толь (Я.Цэвэл)-д морины уяаг зарим нутагт “хондог” гэдэг гэснээс өөр юм үгүй. “Бух” гэдэг үгийн тухайд үзвэл агтлаагүй эр үхэр, бух гөрөөс, бух шувуу, бух нохой, бух тэрэг гэж байна. К.М.Черемисов “Бурятско”русский словарь” (М-1973) толь бичигт “Буха” гэдэг үгийн 2-р утгыг орос хэлээр “Могучий, громадный, огромный” гэсэн утгатай

гэж тайлаад “Буха улаан шинээн-могучая лественница, “Буха ехэ хүүргэ-грамодный мост” гээд Бух хар нум, бух чулуу гэж ардын аман зохиолд гардаг⁽¹⁵⁾ гэжээ. Үүнчлэн “Словарь современного русского литературного языка” (М.-Л.-1959) толь бичигт “бука” гэдэг үгийн 2-р утгыг ярианы хэлнээ бага хүүхдийг “Бука” гэж айлгадаг гээд Чернышевскийгээс жишээ авсан байдаг. 1977 онд Москвад “Русский язык” хэвлэлийн газарт хэвлэсэн “Калмыцко-русский словарь”-д “бух” гэдэг үгийн 2-р утгыг ярианы хэлнээ “(цэргийн) хороо” гэдэг гэж тайлжээ.

Эд бүхнийг нэгтгэн дүгнэж үзвэл одоогийн бидний хэлээр “Наадам, их найр”, бидний өмнөх үеийнхний хэлээр “хуралдай, их хурим, их хуралдай”, тэр үедээ “Бух сужигай-их хүрээ” гэж байна. Өөрөөр хэлбэл Их хүрээг эртний монгол хэлээр “бух-а сужигай” гэж бичсэн болж таарч байна.

Аливаа хэлний идэвхгүй үгс мартагдан мартагдсаар газрын нэр болж, утгагүй үгс мэт болдог үзэгдэл ганц монгол хэлд төдийгүй нийт хэлний түгээмэл үзэгдэл буй заа.

Эшлэл, зүүлт

1. Пэрлээ “Гурван өгүүлэл” УБ., 23 дахь тал.
2. Д.Оссон “Histoire des Mongols” t.I, p.325.
3. Рашид-эд-Дин (Сборник летописей т.1 кн.2, м.л-1952 стр.230): Бука-су-джиху (?) гэжээ
4. Монгол утга зохиолд олон хэлбэртэй болсны гол шалтгаан нь монгол хуучин бичигт “о,у эгшиг адил хэлбэртэй, ж, з, ч, ц, с, шавиа сэлгэдэг. Үгийн эхний “о”-г сүүлийн үед “у” гэж бичээд байгаа нь эртний түрэг, монгол хэлнээ цэргийг “су” гэдэг байсан (Г.Айдаров “Язык Орхонского памятника Бильге кагана” АА-1966.85-87 дахь талд үз) тэр утгаа хадгалсаар байж болно.
5. Ин.Илюкин “Древнейшая Монгольская надпись на Хархираском (“Чингисовом”) камне” Труды гос.Дальневост. Ун-та, серия VI.№ 5. Владивосток-1927.стр.9
6. Мөн тэнд
7. Мөн тэнд
8. Доржи Банзаров. "Собрание сочинений" Москва., 1955. стр.187-206.
9. Х.Пэрлээ “Гурван өгүүлэл”. УБ., 1962. 17 дахь тал.
10. "Жангар" Мөгдөн., 1958. 327, 329, 333, 335, 302 дахь тал
11. Монголч эрдэмтний III их хурал. II боть, УБ., 1979. 302 дахь тал. үзмү.
12. Пэрлээ. Гурван өгүүлэл УБ., 1962 7 дахь тал
13. Э.Вандуй “Зарим нутгийн аман аялгууны үгсийн сангийн тухай” УБ., 1957. 8 дахь тал
14. Сэцэнцогт “Монгол үгсийн язгуурын толь”-д судаг сужиг хоёрыг адил утгатай гэжээ. (Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо. 1988 он. 1669 дэх тал)
15. К.М.Чермисов “Бурятско-Русский словарь” изд. “Советская энциклопедия” М., 1973. 119 дэх тал.